

**Эм Эн Ди ХК-ийн 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Жилийн үйл ажиллагааны тайлан /Маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг	
Тайлагнах хугацаа:	2021 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2021 оны 12-р сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	"Эм Эн Ди" ХК УБГД: 9010001143 Үнэт цаасны код: DLH Утасны дугаар:
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар :	Гадаад худалдаа, Фермерийн аж ахуй, Түргэн хоолны үйлчилгээ, Түрээсийн үйлчилгээ
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт	97360
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн	Жилийн тайланг бэлтгэсэн: Нягтлан бодогч Г.Ганбат ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтуяа Хянасан: Гүйцэтгэх захирал Н.Отгон-Од
1	Тайлант жилийн санхүүгийн тайлан (хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, Санхүүгийн байдлын үзүүлэлт Орлогын тайлан Өмчийн өөрчлөлтийн тайлан Мөнгөн гүйлгээний тайлан
	Аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг хавсаргав.
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт Аудитын тайлан дүгнэлтийг хавсаргав.
1.2	Аудитын тодорхойлох захидал (тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурьдсан агуулгын Аудитын тодорхойлох захидлыг хавсаргав.
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр
2.1	Үйл ажиллагааны үр /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд $ROA = (0,62)$ $ROE = 1,69$ $EPS = 114,8$
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт $ROTA = 1,37$
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл Дэлхий нийтэд үүсээд байгаа цар тахлын нөхцөл байдлын улмаас манай барилгын материалын худалдааны төвийн түрээслэгчдийн гадаад, дотоод худалдааны эргэлт удааширч, бараа татан авалт доголдож байгаа нь тус компанийн түрээсийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, түрээсийн төлбөр төлөлт удааширах магадлал гарч болзошгүй юм. Гэсэн хэдий ч манай компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.



2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого (off balance)	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл:	Тайлант хугацаанд авсан зээл байхгүй.
3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.	
4	Цалин урамшууллын мэдээлэл: Тус компани нь 2021 онд ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагад цалин хөлс, урамшууллыг үйл ажиллагаа чигдэртэл олгоогүй болно.	
5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл: "ЭМЭН ДИ" ХК нь Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд багтдаг нээлттэй хувьцаат компани бөгөөд эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Бид компанийн үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамигаас хамгаалах тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль зэрэг хуулиудыг болон Компанийн засаглалын кодекс, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржээс гаргасан холбогдох дүрэм, журмыг баримталж ажилладаг.  Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байдаг. Компанийн 2021 оны 04-р сарын 28-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн 9 гишүүнийг 1 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн сонгосон. Манай компани нь Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тухай бүр нь холбогдох хууль журмын дагуу СЗХ, МХБирж, мөн өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлсээр ирсэн бөгөөд ТУЗ-ийн гишүүд болон нарийн бичгийн дарга нь Компанийн засаглалын сургалтанд бүрэн хамрагдсан, ажил амьдралын туршилагатай банк, санхүү, бизнес, хууль эрхзүйн мэргэжилтэй удирдах ажилтнууд байдаг. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх 3 хороо нь дараах бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд: 1. Нэр дэвшүүлэх хорооны даргаар Ц.Болд гишүүнээр Н.Отгон-Од, О.Мөнхдалай 2. Цалин, урамшууллын хорооны даргаар Н.Отгон-Од гишүүнээр Н.Ганчимэг, Б.Сарнай 3. Аудитын хорооны даргаар Н.Ганчимэг гишүүнээр О.Мөнхдалай, Б.Сарнай Компанийн ТУЗ нь 2021 онд 1 удаа цахимаар, 1 удаа танхимаар хуралдаж, нийт 8 тогтоол шийдвэрүүдийг гаргасан. Хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүд бүрэн хэрэгжсэн болно.	
6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл Манай компани нь уул уурхайн операторын үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.	
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл (4 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо)	



Манай компани нь 2021 оны 4-р сарын 06-ны бүртгэлийн өдрөөр нийт 97,360 хувьцаа эзэмшигчидтэй байсан. Компанийн 4 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчидийн тоо нь 82 эзэмшигчид.

8

Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл:

Олон нийтэд шинээр санал болгон хувьцаа гаргаагүй болно.

9 Ногдол ашгийн мэдээлэл :

Манай компани нь санхүүгийн тайландаа бүтэн жилээр 1 удаа аудит хийлгэж, ногдол ашиг хуваарилаагүй бөгөөд ногдол ашиг холбогдох журмын дагуу СЗХ, МХБирж болон өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол тайлагнаж ирсэн.

1. Компанийн ТУЗ-ийн 2021 оны 2-р сарын 08-ны өдрийн хурлын 2 тоот тогтоолын дагуу ногдол ашиг хувиарлахгүй байгаахаар тогтоож, тогтоолыг холбогдох СЗХ, МХБирж-д хүргүүлсэн

10

Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл :

Үйл ажиллагаа тогтворжоогүй байгаа тул хийгдээгүй байгаа.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Н.Отгон-Од  
Албан тушаал: "ЭМ ЭН ДИ" ХК-ийн  
Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



Овог, нэр: М.Сэвжидмаа  
Албан тушаал: "Си Эс Ай" аудитын компанийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2022 оны .....-р сарын .....-ны өдөр

Овог, нэр: Б.Эрдэнэтуяа

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

Гарын үсэг: .....